

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ хийж дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна.

Дүгнэлт:

Тус төлөвлөгөө нь 7 зорилгын 114 зорилт, 340 арга хэмжээтэй төлөвлөгдсөн бөгөөд аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2026 онд хэрэгжүүлэхээр тусгасан 4 үндсэн бодлогод хамаарах 107 зорилт, 278 арга хэмжээг тусгаж 1.1.1.2.6, 3.2.6.4.1, 4.1.1.4.1 дэх заалт арга хэмжээг орхигдуулсан байна.

Нийт 26 шалгуур үзүүлэлт нь хэмжигдэхүйц биш байгаа бөгөөд 144 арга хэмжээний суурь түвшин, зорилтот түвшинг шалгуур үзүүлэлтийн утгад тохирох утгаар илэрхийлээгүй байна. (аж ахуйн тасгийн арга хэмжээнүүд бүгд шалгуур үзүүлэлтийн утгад тохироогүй суурь түвшин, зорилтот түвшинтэй байна)

Зорилтот түвшинг тодорхой тусгаагүй эсвэл ямар нэг утга авахгүй тэмдэг, тэмдэглэгээгээр (-, +) илэрхийлсэн зэрэг алдаатай зүйлүүд байгаа нь Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-аар үнэлэх боломжгүй байдал үүсгэхээр байна.

Зөвлөмж:

- Шалгуур үзүүлэлтийг хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтээр оновчтой тодорхойлох

- Суурь түвшинг тухайн арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгаар илэрхийлэх

- Зорилтот түвшинг тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгаар илэрхийлэх

- Суурь түвшинг 2025 оны холбогдох бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилттэй тулгаж нягтлах (АЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилт, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилт, аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх 2025 оны хэрэгжилт г.м)

- Хэлтсүүдийн нэгтгэж болох арга хэмжээнүүдийг нэгдсэн байдлаар нэг арга хэмжээ болгон оруулах (архив албан хэрэг хөтлөлт, сайдын гэрээ г.м)

- Зөвхөн тухайн хэлтэст хамаарах болон тухайн нэг сайдын гэрээнд хамаарах заалт арга хэмжээнүүдийг хасах (цэргийн штаб)

- Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 2.3.4-т хамаарах заалтууд орсон эсэхийг дахин нягтлах

Дээр дурдсан заалт, арга хэмжээнүүдийг хавсралтаар хүргүүлж буй зөвлөмжийн дагуу засварлан батлах шаардлагатай.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

